

**СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ**

НЭГ. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД

а/ Сумын ИТХ-ын ажлын чиглэлээр: Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн ээлжит хурал 2021 оны 1 сарын 7-ны өдөр хуралдан дараах 2 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

1. Сумын ИТХ ын ээлжитбус 4-р хуралдааны тов тогтоох тухай

2. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх татварын байцаагчийн мэдээлэл, мөн ажлын хэсгийн дүгнэлтийг сонсох

3. Сумын ИТХ-ын ээлжит бус 4 дүгээр хуралдаан 2021 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 14 цагт Нутгийн удирдлагын холбооны Иргэний танхимд хуралдан малын тоо толгойн албан татварыг 5 төрлөөр нь тогтоон ажиллаа. Адуу-1000 төгрөг, хонь-500 төгрөг, үхэр-500 төгрөг, ямаа -600 төгрөг байхаар шийдвэрлэлээ. Мөн малын тоо толгойн албан татвараас малчны амжиргааг дэмжих зорилгоор малчны өмчилж байгаа малын тоо толгойноос хамааран ноогдох албан татварын хэмжээг 0 төгрөг байхаар хурлын тогтоол шийдвэр гарч холбогдох дээд шатны байгууллага газарт нь хүргүүлэн ажиллаа. Мөн сумын зарим газар нутгийг тусгай хамгаалалтанд авахаар хурлын тогтоол шийдвэрүүд нь гарлаа.

2020 оны ИТХ-ын тогтоол, захирамж болон бусад албан бичгүүдийг үдэж хадгаламжийн нэгж болгон архивлан ажиллаж байна.

б/ Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

2020 оны жилийн эцсийн хүн ам, мал тооллогын ажлыг сумын Засаг даргын 12 сарын 17-ны өдрийн 121 тоот захирамжаар 12 сарын 18-наас 12 сарын 28 хүртэл 10 хоног зохион байгуулж, 2021 оны 1 дүгээр сарын 5-8 ны өдрүүдэд аймгийн статистикийн хэлтэст хүргүүлэн ажиллалаа. Аймгийн ИТХ-ын дарга Хосбаяраар ахлуулсан ажлын хэсэг 1 дүгээр сарын 11-ний өдөр тус сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж ажиллалаа. 1 дүгээр сарын 15 ны өдөр ЭМТ, МХЕГ, ОБГ –ын хамтарсан шалгалт ирж Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, тусгаарлах байрны бэлэн байдалд шалгалт хийн ажиллав. Засаг дарга 3 р багийн иргэд малчидтай 1 дүгээр сарын 15-17 ны өдрүүдэд уулзаж өвөлжилтийн байдалтай биечлэн танилцаж ажилласан.

ХОЁР. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Орон нутгийн санхүүгийн дэмжлэг ирээгүй. Орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдлээс 53891.8 мянган төгрөгийн санхүүжилтийг төсвийн 3 байууллагад өглөө.

Татварын орлогоор 1314.2 мянган төгрөг төвлөрсөн. 2021 оны ОНХС-аар 5 төсөл, хөтөлбөр хийгдэхээр сумын ИТХ-аар батлуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг tender.gov.mn сайтад шивлээ.

2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 6 төсөвт байгууллага, ОНХС, СХС, Эмийн эргэлтийн сан, төрийн сангаар гарган хуулийн хугацаанд аймгийн төрийн аудитын байгууллагад хүргүүлээ.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АЖЛЫН ХҮРЭЭНД:

Хөдөлмөр халамжын мэргэжилтэн Алдарт эхийн одон болон насны хишиг мэдээллээ шинэчлэн гаргах талаар мэдээлэл хийлээ. Мөн засгийн газрын 2020 оны 217

дугаар тогтоол байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журмаар сонсгол мэдээллийн цагаар мэдээлэл хийж ажиллав.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

ЕБС: 1-9р ангийн сурагчдад даалгаварын сан бэлтгэж, теле хичээл үзэх боломжгүй сурагчдад нэмэлт даалгавар боловсруулж, эргэх холбоотой ажилласан.

Багш ажилчид болон, байгууллагаар үйлчлүүлж байгаа ард иргэдийн халууныг тогтмол үзэж, бүртгэл хөтлөн ажиллаж байна. МУЗГ, Аймгийн засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын 0-12 насны хүүхэдтэй 11 албан хаагчийн хүсэлт, ажлын нөхцөл байдлаас шалтгаалан цахим хэлбэрээр ажлаа хийх нөхцөл боломжоор ханган гэрээр ажиллуулж байна

Хорио цээрийн дэглэмд шилжиж цахимаар ажил үүргээ гүйцэтгэж байгаа энэ үед багш нар мэдээлэл харилцаа технологийн чадвараа сайжруулж багшийн туслах, econtent, khanacademy, powtoon, bandicom зэрэг праграммууд дээр ажиллаж сурагчдад зөвлөмж, зөвлөгөө, цахим хичээл бэлтгэн хүргэж байна.

Дотуур байр болон хичээлийн байрны анги танхим, өрөө тасалгаа бүрийг 1-р сарын 17-ны өдөр сумын ЭМТ-р ариутгал, халдваргүйтгэл хийлгэсэн.

ЭМТ: 1 дүгээр сард гэрийн ажиглалтанд 10 иргэн байна. covid Шинжилгээг– 4 хүнд түргэвчилсэн тестээр хийхэд сөрөг гарсан. 2021 оны 1дүгээр сард нийт үзлэг 120, үүнээс 10 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн байна.

ХХАА-н чиглэлийн ажлаар: 2020 оны жилийн эцсийн хүн ам, малын тооллогын ажил 2020 оны 12-р сарын 18-наас -28 ны хооронд явагдаж, 2021 оны 1-р сарын бнд Аймгийн статистикийн газар цаг хугацаанд нь амжилттай тушаалаа. Энэ жил өрх хүн ам, мал өссөн үзүүлэлттэй.

Улсын аварга малчны 1 материал, Аймгийн сайн малчны 4 материалыг болзлын дагуу бэлтгэж холбогдох газарт хүргүүлээ.

Монгол улсын засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолын дагуу Арьс ширний урамшуулалд 199 өрхийн хонины арьс-15541, ямааны арьс-1739, адууны шир-55, үхрийн шир-8326 бүгд 25660 арьс ширний материалын жагсаалтыг холбогдох газарт нь явууллаа.

Мал эмнэлэг: Аймгийн мал эмнэлгийн газар, сумын засаг дарга, мал эмнэлгийн тасагтай байгуулсан үр дүнгийн гэрээгээр ажилаа дүгнүүлж аймгийн хэмжээнд 3-р байранд орлоо.

Сумын засаг дарга, мал эмнэлгийн тасаг , ХХМЭ-үүдтэй 2020 онд байгуулсан үр дүнгийн гэрээг дүгнэж нийт 16 асуумж 80 оноогоор дүгнэн “Боорчи баруун урт” мал эмнэлэг тэргүүн байр эзлэж шилжин явах цом, дурсгалын зүйлээр шагналаа.

Бруцеллёз өвчинөөс урьдчилан сэргийлэх тарилгын захиалгыг аймгийн мал эмнэлгийн газарт хүргүүлээ.

Байгаль орчны чиглэлээр:

Баян шарга уулын орчмын 190887.965 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах тухай тогтоолын төслийн боловсруулан сумын ИТХ-ын 3 дугаар хуралдаанд оруулсан.

Сумын засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт байгаль орчны чиглэлээр хийх ажлын саналыг засаг даргатай зөвшилцөн оруулсан.

ХЯНАСАН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА:
МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ХШҮ-ДОТООД АЖИЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

М.БАТБЭХ
Д.ДАЙРИЙМАА